



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/70

Мандалговь

“Дөл БГМ” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”- 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн А/43 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Цэцэрлэгийн барилгын засвар (Дундговь, Сайнцагаан сум, 4 цэцэрлэг) ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Дөл БГМ” ХХК-тай 36,300,000 (гучин зургаан сая гурван зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу Цэцэрлэгийн барилгын засварын ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Дөл БГМ” ХХК-ны гүйцэтгэх захирал (Б.Мөнхбаяр)-д үүрэг болгосугай.

Гурав.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (А.Нарантуяа), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060309